



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ, ҮР ДҮНД
СУУРИЛСАН САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦОО
ҮР НӨЛӨӨ ГҮЦЭТГЭЛИЙН АУДИТЫН
ТАЙЛАНГААС



2023 ОН



Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө

Аудитын зорилт


Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө сэдвээр гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, гарган холбогдох байгууллагад хүргүүлэх



Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны "Аудитын сэдэв батлах тухай" 2022 оны 9 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-г тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.



Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө



УИХ-аас 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдөр Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийг хийх хууль эрх зүйн орчныг бий болгож Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Тус хуулийн өөрчлөлтөөр эрүүл мэндийн салбарт санхүүжилтийн тогтолцоогоор дамжсан шинэчлэлийг эхлүүлсэн бөгөөд дараах 6 зорилтыг дэвшүүлжээ.

1

Улсын төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн салангид үр ашиггүй эх үүсвэрүүдийг эрүүл мэндийн даатгалын санд нэгтгэж, нэг худалдан авагчийн тогтолцоод шилжүүлэх.

2

Эрүүл мэндийн даатгалын сангийн даатгуулагчдад үзүүлэх санхүүгийн хамгаалалтыг нэмэгдүүлэх зорилгоор жилийн дээд хязгаарыг хүчингүй болгох.

3

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг хянах, үнэлэх тогтолцоог бий болгож, санхүүжилттэй уялдуулах.

4

Эмийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, үнийг бууруулах.

5

Хөнгөлөлттэй эмийн хүртээмжийг нэмэгдүүлж, чирэгдлийг арилгах.

6

Ажлын гүйцэтгэлтэй уялдсан цалин урамшууллын тогтолцоог бий болгох.



Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө



2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Эрүүл мэндийн даатгалын холбогдох хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд хэрэгжиж эхэлснээр эмнэлэг дагасан санхүүжилтийн хуучин тогтолцоог өөрчилж, даатгуулагч иргэн, үйлчлүүлэгчээ дагасан санхүүжилтийн тогтолцоо хэрэгжиж эхэлсэн байна.

Аймгийн хэмжээнд ЭМДС-ийн үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүрэгтэй Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь дарга 1, чанар төлбөрийн хяналтын мэргэжилтэн 4, нийт 5 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна

Санхүүжилтийн шинэ тогтолцоонд шилжсэнээр Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн үндэсний эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдэж эхэлсэн байна.

Санхүүжилтийн шинэ тогтолцоонд шилжсэнтэй холбогдуулан Эрүүл мэндийн салбарын шинэчлэл, гүйцэтгэлийн санхүүжилтийн чухал хэсэг болох Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дараах тогтоол журам гарсан байна. Үүнд

2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 03 дугаар тогтоолоор "Тусламж, үйлчилгээний санхүүжилтийн шинэчилсэн жагсаалт, журам, тариф"



2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 01 дүгээр "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" тогтоол гаргаж Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 03 дугаар тогтоолыг хүчингүй болгосон



2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 02 дугаар "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам"





Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө

Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагын төлөвлөгөөг Эрүүл мэндийн даатгалын системийн хэмжээнд баталж аймгуудад олгох санхүүжилтийг гүйцэтгэлд суурилан олгож байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр 2021 онд 20,807.2 сая, 2022 онд 31,130.8 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.

Эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалт 2022 онд 10,323.6 сая төгрөгөөр өсөхөд дараах хүчин зүйл нөлөөлсөн байна. Үүнд:

Эрүүл мэндийн даатгалын сангийн зардлыг өмнөх оны 9 дүгээр сараас гүйцэтгэлээр санхүүжүүлдэг болсон.

Ковид цар тахлын үеийн эмчилгээний болон шинжилгээ оношилгооны зардлыг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлсэн.



Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 01 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар "Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж үйлчилгээний оношны хамааралтай бүлгийн жагсаалт, төлбөрийн хэмжээ"-г баталсан байна.

Уг жагсаалтад оношны хамааралтай 705 бүлэг үйлчилгээг тусгасан байх бөгөөд тухайн эмнэлгийн тусгай зөвшөөрөлд заагдсан үйл ажиллагааны хүрээнд гэрээ байгуулан шаардлага хангасан багц үйлчилгээний төрлийг санхүүжүүлэхээр баталдаг байна. Манай аймгийн хувьд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай гэрээ байгуулан үйл ажиллагаа явуулж байгаа 4 эмнэлэг байна. Үүнд: аймгийн Нэгдсэн эмнэлэгт 350 багц үйлчилгээ, ЭБАЖИ ХХК-ийн эмнэлэгт 29 багц үйлчилгээ, Увс-Мөнхтэнгэр ХХК-ийн "Жаргалан" эмнэлэгт 14 багц үйлчилгээ, Зөв онош ХХК-ийн эмнэлэг 26 багц үйлчилгээ үзүүлэхээр ЭМДҮЗ-ийн 2022 оны 02 дугаар тогтоолоор "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам"-ын дагуу сонгон шалгаруулалт зарлан гэрээ байгуулсан байна.





Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө

ҮАГ-ын нэгдсэн тайланд тусгуулахаар дараах саналуудыг хүргүүлж байна. Үүнд

1

Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын сонгон шалгаруулах үйл ажиллагааг явуулж гэрээг байгуулахдаа тухайн эрүүл мэндийн байгууллагын саналыг тусгаж байх.

2

Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах тусламж үйлчилгээг санхүүжүүлэх төлбөрийн арга-ын 3.3-д "Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газар нь суурь тарифыг өөрчлөх шаардлагатай эсэхэд жил бүр дүн шинжилгээ хийнэ" гэж заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний суурь тарифын хэмжээг шинэчлэн тогтоох.

3

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөлтийг бодитой хийж байх.

4

E-barimt ашиглан өөрийн харьяалагдах сумыг сонгож эрүүл мэндийн шимтгэлийн төлбөр төлсөн тохиолдолд тухайн даатгуулагчийн орлогыг тухайн суманд нь төвлөрүүлэх.

5

E-barimt ашиглан эрүүл мэндийн шимтгэл төлсөн даатгуулагчийн орлогыг харилцахын системд автоматаар татагддаг болгох.

6

Хууль журмын дагуу эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөхөөс чөлөөлөгдсөн болон албан журмын даатгуулагч E-barimt ашиглан эрүүл мэндийн шимтгэл төлөх тохиолдолд шимтгэл давхардаж байгаа талаар санамж өгдөг байх зохицуулалт хийх.

7

Орон нутаг дахь Эрүүл мэндийн даатгалын байгууллагыг <https://shilendans.gov.mn/> цахим мэдээллийн санд мэдээлэл оруулах цэстэй болгох.

8

Эрүүл мэндийн даатгалын орлогын төлөвлөгөө, өөрөө эрүүл мэндийн даатгалаа төлдөг иргэдийн хамралтын төлөвлөгөөний биелэлт жил бүр хангалтгүй байдаг манай аймгийн нийт хүн амын 77.9 хувийг эрүүл мэндийн даатгалыг төрөөс хариуцдаг иргэд эзэлж, хамралтын төлөвлөгөө биелэлт хангагдахгүй байдаг тул эрүүл мэндийн даатгалын орлого, хамралтыг төлөвлөхдөө тухайн хүн амын төр хариуцах иргэдийг хасаж батлуулах.

9

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 19.3 дахь заалтын дагуу Нийгмийн даатгалын тухай хуулиар зохицуулж байгаа тул хамтран ажиллах гэрээнд Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогыг биелүүлэх заалтыг оруулж тусгах.

10

Эрүүл мэндийн даатгалын хуулийн хүрээнд төр хариуцах иргэд хамтын төлбөргүй тусламж үйлчилгээ авдаг бөгөөд тусламж үйлчилгээний зардлыг 100% эрүүл мэндийн даатгалын сангаас гаргуулдаг бөгөөд тухайн бүлгийн иргэдийн авсан зардал нь сангийн дийлэнх хувийг эзэлж сангийн ачааллыг нэмэх, шаардлагагүй хэвтэлтийг үүсгэх, буруу хандлагыг үүсгэж байгаа тул хамтын төлбөртэй болгох.